

**“ХАРХОРИН” ХК-ИЙН 2020 ОНЫ 04 САРЫН 29 ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 04 сарын 29 өдөр

Хархорин сум

“Хархорин” нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 сарын 29 өдөр 14.00 цагаас Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байранд хурлын танхимд хуралдсан болно. Covid 19 коронавирусын халдвартай холбоотойгоор “Хархорин” ХК-ийн 2020 оны 4 сарын 29 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хувьцаа эзэмшигчдийг аль болох нэг газар олноор цуглуулахгүй хуралдуулах, хувьцаа эзэмшигч нарт хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой мэдээлэл, баримт бичиг, хурлаас гарах тогтоолын төслүүдийг урьдчилан танилцуулж саналыг нь саналын хуудсаар авах зэрэг халдвар авахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.

Хурлын бүртгэлийн өдөр 2020 оны 04 сарын 06-ны өдрөөр саналын эрх бүхий нийт 577 хувьцаа эзэмшигчид саналаа ирүүлэхээс нийт 378,146 ш хувьцаа эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигч саналаа ирүүлсэн. Ирцийн тайлан дараах байдалтай байна:

д.д	Хуралд оролцсон, саналаа хэрхэн өгсөн	Хувьцаа эзэмшигчийн тоо	Хувьцааны тоо
1	Хуралд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцсон	-	-
2	Саналаа саналын хуудсаар ирүүлсэн	6	378,146
	Нийт	6	378,146

Компанийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу саналын хуудсаар саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсонд тооцсон.

Хуралд хурлын дарга П.Учрал, “Хархорин” ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Саранцэцэг, ерөнхий нягтлан бодогч Д.Дашмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ганбат, ерөнхий агрономич Б.Бямбасүрэн нар биечлэн оролцсон. ТУЗ-ийн дарга П.Бишрэл, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бүрэн, Б.Амарсанаа нар гар утсаараа холбогдож (чанга яригч дээр тавьж) оролцсон.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Ганбат

Тус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2020 оны 3 сарын 16 өдрийн 02/2020 тоот тогтоолоор гаргасан. Хурлын мэдэгдлийг 2020 оны 03-р сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсэн.

Хурлыг зарлан хуралдуулах ажлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хийсэн болно.

Хурал болсон газар: Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтолгой баг, Усжуулах 00 хаягаар байрлах компанийн өөрийн байр

Хурал болсон он, сар, өдөр, цаг: 2020 оны 04 сарын 29 өдөр 14.00 цаг

Хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: Пүрэвийн Учрал

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. Компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах,
4. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах.

Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц:

“Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хуралд тус бүр нэг саналын эрх бүхий 539,515 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 577 хувьцаа эзэмшигчдийн санал ирэхээс нийт 378,146 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигчид саналаа саналын хуудсаар ирүүлж, хурлын ирц 70.09 хувь болсон.

Саналын хуудас хэрэглэсэн эсэх, саналын хуудасны загвар: Хархорин ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2020 оны 3 сарын 16 өдрийн 02/2020 тоот тогтоолын 2-р хавсралтаар компанийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 4 сарын 29 өдрийн ээлжит хуралд хэрэглэх саналын хуудасны загварыг баталж тус саналын хуудсаар санал хураалт явуулсан болно (Компанийн тухай хуулийн 71.1-ийн дагуу). Саналын хуудасны загварыг энэхүү тэмдэглэлд хавсаргав¹.

Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол:

Асуудал 1: Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

1-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалдсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0.

1-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хавсралтаар батлав.

Асуудал 2: Компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

2-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0.

¹ Хавсралт 1

2-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгож компанийн 2019 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хавсралтаар батлав.

Асуудал 3: Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг батлах тухай

3-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0.

3-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 01/2020 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгож “Хархорин” ХК нь 2019 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 147,025.7 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөв.

Асуудал 4: Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах тухай

4-р асуудлаар зөвшөөрсөн саналын тоо: 378,146; татгалзсан саналын тоо: 0; түдгэлзсэн саналын тоо: 0.

4-р асуудлаар гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол: “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас “Хархорин” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталж, тус төлөвлөгөөний бислэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгав.

Хурал өндөрлөсөн: 15.20 цагт

Хурлын дарга



П.Учрал

Хурлын тэмдэглэл
хөтөлсөн:

Б.Ганбат

Хавсралт 1: “Хархорин” ХК-ийн 2020 оны 04 сарын 29 өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэрэглэсэн саналын хуудасны загвар

“Хархорин” нээлттэй ХК-ийн ТҮЗ-ийн
2020 оны 03 -р сарын 16-ны өдрийн 02/2020 тоот
тогтоолын Хавсралт 2

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

“Хархорин” нээлттэй ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 14.00 цагт Өвөрхангай аймаг, Хархорин сум, Эрдэнэтөлгой баг, Усжуулах 00 тоот хаягаар байрлах компанийн өөрийн байрны хурлын танхимд хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дутаар Регистрийн дутаар

Санал өгөх хувьцааны тоо Кумулятив саналын тоо

Бүртгэсэн: / БДК-ийн нэр /

Брокерын овог нэр

Ердийн аргаар санал хураах асуудлууд

Д/д	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2019 оны үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах			
2	Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах			
3	Погдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг батлах			
4	Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах			

Жаг: “Зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” ашиг болохыг чагтална / **зөвхөн нэгийг нь** /

Хувьцаа эзэмшигч /

Брокер /

(Хэрвээ саналаа өөрийн үйлчилгээнд брокер, дилерийн компанитай дамжуулан өгч байгаа бол тухайн саналын хуудсыг хүлээн авсан брокер гарын үсэг зурж тэмдэг дарсан байна)

(арын нүүрийг үзнэ үү)

САНАМЖ

"COVID-19" коронавируст халдвар дэгдсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цугларуулахгүйгээр цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн өнцлөт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй гэж Санхүүгийн зохицуулах хорооноос өгч байгаа зөвлөмжийн дагуу "Хархорин" ХК-ийн Хувьцаа эзэмшигч та хуралд ирж биечлэн оролцохгүйгээр өөрийн саналаа дараах байдлаар өгөх боломжтой:

1. Хурал зохион байгуулах комиссын ganbat.battorgtokh@gmail.com цахим хаягаар өөрийн иргэний үнэмлэхний хуулбарыг илгээнэ. Хурал зохион байгуулах комисс нь Таны иргэний үнэмлэхний хуулбарыг хүлээн аваад 2020 оны 04-р сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч мөн эсэхийг лавлаж бүртгэж авна. Асууж лавлах зүйл байгаа бол Хурал зохион байгуулах комисстэй 99993800, 94186636 тоот утсаар ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагт холбогдож болно.
2. Хурал зохион байгуулах комисс нь Таны цахим шуудангийн хаягаар хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой баримт материал, саналын хуудас зэргийг pdf хэлбэрээр илгээнэ.
3. Хувьцаа эзэмшигч та хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой баримт материалтай танилцаад өөрийн саналыг хуудсыг бөглөнө. Ингэхдээ саналын хуудсыг хэлэлцэж өөрийн овог, нэр, регистрийн дугаар, хувьцааны тоо зэргийг бөглөнө. Үүний дараагаар санал тус бүр дээр "зөвшөөрсөн", "тагталтсан", "гүдгэлзсэн" албан болохыг чагтална. Асуудал тус бүрийн "зөвшөөрсөн", "тагталтсан", "гүдгэлзсэн" гэсэн саналын хувилбаруудаас эвххөн нэгийг нь чагтална. Үүний дараагаар гарын үсгээ зурна.
4. Санал авах хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
5. Саналын хуудсаа компанийн хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр хурал хуралдахаас ажлын 5 хоногийн өмнө хүргэж өгөх, эсхүл баталгаат шуудантаар хурал хуралдахаас ажлын 5 хоногийн өмнө "Хархорин" ХК, ХЭХ Зохион байгуулах комисс, Оновхантай аймаг, Хархорин сум, Эрдэнэтөлгой баг, Усжуулах 00 хаягаар илгээнэ. (Яич: саналын хуудас шуудантаар хүргэгдэхэд хугацаа орох тул ийнхүү хурал хуралдахаас ажлын 5 хоногийн өмнө шууданд өгөх нь зүйтэй).
6. Хэрвээ энэ хугацаанаас хоцорсон бол Хурал зохион байгуулах комисстэй 99993800, 94186636 тоот утсаар холбогдож заавар авна.
7. Хэрвээ хувьцаа эзэмшигч нь Хурал зохион байгуулах комисстэй биечлэн уулзах шаардлагатай бол тус комиссын 99993800, 94186636 тоот утсаар холбогдож цаг товлож уулзах боломжтой.